

ТАНИЛЦУУЛГА

“Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ын төслийн талаар

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журмыг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.” гэж заасныг үндэслэн “Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2007 оны 58/62 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-ыг баталсан.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 435.762 этгээд эрүүлжүүлэх байранд хүлээн авснаас 2018 онд 85.840 этгээдийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 657 нэгж буюу 0.8 хувиар буурсан, 2019 онд 111.076 этгээд ийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 25.293 нэгж буюу 29.4 хувиар өссөн, 2020 онд 93.861 этгээдийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны үеэс 17.218 нэгж буюу 15.5 хувиар, 2021 онд 70.479 этгээдийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны үеэс 23.384 нэгж буюу 24.9 хувиар, 2022 онд 63.879 этгээдийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны үеэс 6.600 нэгж буюу 9.3 хувиар, мөн энэ оны 09 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 11.691 этгээдийг эрүүлжүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 38.973 нэгж буюу 76.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээллийн сангаас авсан мэдээллээр 2018 онд 85.840 этгээдийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 281.5 сая, 2019 онд 111.076 этгээдийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 341.2 сая, 2020 онд 93.863 этгээдийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 288.8 сая, 2021 онд 70.479 этгээдийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 252.4 сая, 2022 онд 63.879 этгээдийг эрүүлжүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт 218.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст үйлчлэх эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн болон үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд тавигдах шаардлагыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/18 дугаар тушаалаар баталсан “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS5527:2019 стандартаар зохицуулсан бөгөөд стандартын “А” хавсралтад техник хэрэгсэл, тусгай хэрэгсэл, эд зүйлсийг, “В” хавсралтад эм, тариа, боолтын материал, багаж, хэрэгсэлтэй байхаар заасан.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж албадан эрүүлжүүлэгдсэн хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, тариа, боолтын материалын зардалд 2022 оны байдлаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын эрүүлжүүлэх байранд 1.9 сая төгрөг, орон нутгийн цагдаагийн газарт жилд 1.2 сая төгрөг төсөвлөгдөж байгаа нь дунджаар 1 үйлчлүүлэгчид 305 төгрөг зарцуулах тооцоо гарч, төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан эрүүлжүүлэгдсэн этгээдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шаардлагын түвшинд шуурхай үзүүлж чадахгүй байх нөхцөл байдал үүсэхээр байна.

“Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2007 оны 58/62 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, үйлчилгээний хөлс төлөх журам”-д зааснаар үндсэн 7 төрлийн үйлчилгээнд нэг иргэнээс нийт 4150 төгрөг, нэмэгдэл 5 төрлийн үйлчилгээнд үзүүлсэн

үйлчилгээний төрөл, гүйцэтгэлээс хамааран 100-600 төгрөгийн нэмэгдэл төлбөр авахаар зохицуулсан бөгөөд тухайн үеийг өнөөдрийн үетэй харьцуулахад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор дээрх зардал нь хүрэлцдэггүй, тухайн төлбөрийн хэмжээг тогтоож байх үед буюу 2007 онд инфляцийн түвшин 4.5 хувь, ам.долларын ханш 1.169.97 төгрөг байсан бол одоогийн байдлаар инфляцийн түвшин 13.8 орчим хувьд хүрч, ам.долларын ханш 3485.00 төгрөг болж тус тус өссөн нь одоо мөрдөж байгаа төлбөрийн хэмжээтэй харьцуулахад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн бодит үнэ ханштай нийцэхгүй байгаа бөгөөд эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон тул Эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг өнөөгийн ханштай нийцүүлэх зорилгоор дээрх журмын “үйлчилгээний үндсэн хөлсийг 7000 төгрөг”, “нэмэгдэл хөлсийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эм, тариа, боолтын материал, багаж, хэрэгсэл хэрэглэсэн тухайн үеийн үнийн дүн”-гээр болгож шинэчлэн батлахаар холбогдох төслийг боловсрууллаа.

Төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардахгүй бөгөөд эрүүлжүүлэх байрны үйл ажиллагаа, үйлчлүүлэгчид хүрэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал болон хуульд заасан баталгаа хангагдана гэж үзлээ.

Мөн эрүүлжүүлэх байрны зарим (хоолоор үйлчлэх, эрүүлжүүлэх байрны ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ) гэх зэрэг үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар гэрээ байгуулан хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг бүрдэх юм.

--oOo--